

ТАНИЛЦУУЛГА

*Дотоод хэргийн их сургуулийн
тухай хуулийн төслийн талаар*

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 7.4 -т “Хууль сахиулах салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулан ... мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлнэ.” гэж мэргэшсэн чадварлаг хууль сахиулагч албан хаагчдын хүний нөөцийг бэлтгэх, салбарын эрх зүйн шинэтгэлийг нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэхээр нарийвчлан зохицуулах талаар, түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 74-т Эрх зүйч, хууль сахиулагч бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагын тухай хуулийн төслийг санаачлан боловсруулахаар тус тус заасан.

Дотоод хэргийн их сургууль 1934 онд анх Дотоод явдлын яамны “Төв сургууль” нэртэйгээр үүсгэн байгуулагдсанаас хойш 87 дахь жилдээ сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагаа явуулж, улсыг аюулаас хамгаалах байгууллага, хууль зүй, дотоод хэргийн салбарын хүний нөөцийг бэлтгэж ирсэн шинжлэх ухаан, сургалтын түүхт төв юм.

Тус сургууль нь хил хамгаалах, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээ болон онцгой байдлын зэрэг төрийн тусгай чиг үүргийн байгууллагын хүний нөөцийг боловсролын бүх шатанд бэлтгэдэг цэргийн, цэрэгжсэн, энгийн алба хаагчдаас бүрдсэн бүтцийн хувьд өвөрмөц загвартай байгууллага юм.

Монгол Улсын дотоод хэргийн салбар, тэр дундаа хууль сахиулах албаны хүний нөөцийг бэлтгэх нэгдсэн тогтолцоог бий болгох, албан хаагчдыг үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг практикт нэвтрүүлэх, дотоод, гадаадын байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, их сургуулийн албан хаагч, суралцагчдын эрх зүйн байдлыг тодорхой болгох, баталгаажуулах, тэднийг гэмт хэрэгтэй тэмцэх, аюулгүй байдлыг хангах, улсын хил хамгаалалт, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор үүрэг гүйцэтгүүлэх үндэслэл, хэлбэр болон их сургуулийн зорилтыг хэрэгжүүлэх явцад амь нас, эрүүл мэндээрээ хохирсон, өвчилсөн, халдлагад өртсөн тохиолдолд алба хаагчдын нэгэн адил тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох, нөхөн олговор авах эсэх нь тодорхойгүй байгаа зэрэг бусад хүндрэл бэрхшээлийг арилгах зорилгоор Дотоод хэргийн их сургуулийн тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд Дотоод хэргийн их сургуулийн чиг үүрэг, захирлын бүрэн эрх, алба хаагч, суралцагчдийн эрх, үүргийг тодорхойлж, түүнчлэн их сургуулийн алба хаагч, суралцагч гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, улсын хил хамгаалах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцсон тохиолдолд Цагдаагийн албаны тухай, Дотоодын цэргийн тухай, Монгол Улсын хилийн тухай, Гамшгаас хамгаалах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудад заасан алба хаагчийн нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээж, баталгаагаар хангагддаг байхаар, түүнчлэн Дотоод хэргийн их сургуулийн албан хаагчдын цалингийн сүлжээ, хэмжээг Засгийн газар тусгайлан тогтоохоор зохицууллаа.

Их сургуулийн санхүүжилт нь улсын төсөв болон Монгол Улсын хууль тогтоомжид хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэхээр, сургалт, эрдэм шинжилгээний материаллаг баазыг бэхжүүлэх, ажиллах, суралцах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор их сургууль багш, суралцагч, сургалтын орчныг хөгжүүлэх сантай байж болохоор, мөн дэргэдээ галт зэвсгийн сум үйлдвэрлэх, дахин цэнэглэх, үйлдвэрийн нэгж, оюуны бүтээлийг хэвлэх, борлуулах, эрхлэн гаргах үүрэг бүхий хэвлэлийн үйлдвэр эрхлэх аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газартай байхаар тус тус тусгалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ